



ДУНДГОВЬ АЙМАГ
САЙНЦАГААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 11 сарын 23 өдөр

Дугаар 4/222

Мандалговь

Арга хэмжээ хэрэгжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 "л", Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 34 дүгээр зүйлийн 34.2.2 дахь хэсэг, Засгийн газрын 2020 оны 178 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан хүнсний худалдаа эрхэлж байгаа дэлгүүрүүдээр 18 нас хүртэлх хүүхдэд үйлчилгээ үзүүлэхийг хориглосугай.

2.Засгийн газар болон аймаг сумын Онцгой комиссын шийдвэрүүдийг хэрэгжүүлж ажиллахыг хүнсний худалдаа эрхэлж байгаа Аж ахуй нэгжийн удирдлагуудад үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг сумын Онцгой комиссын гишүүдэд даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Р.МӨНХТОГТОХ

